



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/320

Арвайхээр

**Газар ашиглалтын зориулалтад  
өөрчлөлт оруулах тухай**

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 3.4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хангамж-өргөө ХХК-ийн гаргасан хүсэлтийн дагуу 5 дугаар баг Барилгачдын гудамж 6 тоотод байрлах үйлчилгээний зориулалттай 8301 м<sup>2</sup> газрын зориулалтыг нийтийн орон сууц, иргэн Д.Баяртогтохын эзэмшил 13 дугаар баг Залуучуудын 3 дугаар гудамж 301 тоотод байрлах үйлчилгээний зориулалттай 500 м<sup>2</sup> газрын зориулалтыг нийтийн орон сууцны зориулалттай болгон тус тус өөрчлөлт оруулсугай.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100693